



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 08 сарын 24 өдөр

Дугаар А/339

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дах хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.17 дах заалт, "Супер проб" ХХК-ийн "Мөнгөн гүүр" эмнэлэг болон Бүгд Найрамдах Солонгос Улсын "Ганнам Наннүри" эмнэлэг хооронд 2016 оны 03 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 2 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирал /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081382

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 08 сарын 24-ны өдрийн
А/339 дугаар тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

Овог нэр	Харьяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1. И Гуан Ёл Lee Kwang Yeol	Бүгд Найрамдах Солонгос Улс	"Сулпер проб" ХХК-ийн "Мөнгөн гүүр" эмнэлэг	ГЭ00002095	Гэмтэл согог судлал	Эмчлэх	2018.08.25-2018.08.26 /2 хоног/
2. Ким Хёон Сон Kim Hyeunsung	Бүгд Найрамдах Солонгос Улс	"Сулпер проб" ХХК-ийн "Мөнгөн гүүр" эмнэлэг	ГЭ00002096	Мэдрэлийн мэс засал судлал	Эмчлэх	2018.08.25-2018.08.26 /2 хоног/